



Дотоодын нийт бүтээгдэхүүнийг орлогоор болон зардлаар тооцох нь

Нийгэм судлал 10-р анги

Багш Д.Уранцэцэг

II улирал. Хичээл №1

Email: D.Urantsetseg@must.edu.mn

Утас: 99291533

Хичээлийн зорилго

- 10.4б. Орлого болон зарлагын жишээгээр эдийн засгийн нэгдмэл үзүүлэлтүүдийг тооцоолох
- 10.4в. Эдийн засгийн боломжийг дээд зэргээр ашиглах тухай онолын мэдлэгт үндэслэн амьдрал үйл ажиллагаандаа ашиглах санаануудыг дэвшүүлэх

Тулгуур ойлголт

- ▶ **Дотоодын нийт бүтээгдэхүүн-** тодорхой хугацаанд тухайн оронд бүтээгдсэн **эцсийн бараа болон үйлчилгээнүүдийн зах зээлийн үнийн нийлбэр юм.**
- ▶ **Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн-ДНБ-ийг** нийт хүн амд харьцуулсан үзүүлэлт. X үржүүлнэ $\text{нийт} = 389 \$$
- ▶ **Зардлаар ДНБ-ийг тооцох арга-** Хэрэглэгчийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлбэр дүн юм.
- ▶ **Орлогоор ДНБ-ийг тооцох арга-** Тухайн улсын хэмжээнд жилийн турш үйлдвэрлэсэн баялгийг орлогын нийлбэр дүнгээр тодорхойлох арга.
- ▶ **Нэрлэсэн ДНБ-Өнөөгийн үнээр тооцсон ДНБ**
- ▶ **Бодит ДНБ-Тодорхой буюу зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ**
- ▶ **ДНБ-ний дефлятор (түвшин)-** Дотооддоо үйлдвэрлэсэн бүх бараа, үйлчилгээний үнийн түвшинг харуулдаг.

ДНБ хэрхэн өсөж буурч байгааг буйг тогтмол үнээр тооцож харьцуулдаг. Бодит ДНБ-ийг тодорхойлохдоо тухайн жилийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн түвшний ерөнхий өсөлт буюу инфляцийн түвшинд харьцуулж тодорхойлно.

$$БДНБ = \frac{НДНБ}{I}$$

$$RGDP = NGDP / GDP\ deflator$$

- ▶ $RGDP = NGDP / GDP\ deflator$
- ▶ Бодит ДНБ, $NGDP$
- ▶ Нэрлэсэн ДНБ $GDP\ deflator$
- ▶ I тухайн жилийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлт буюу инфляцийн түвшин

Эх сурвалж.

МОНГОЛБАНК ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

Эдийн засгийг энгийнээр 2018 он №1

- ДНБ-ийг тооцох аргачлал
- • Үйлдвэрлэлийн арга: Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасч, нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцно.
- • Эцсийн ашиглалтын арга: Эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал, цэвэр экспортын (экспорт-импортын зөрүү) нийлбэрээр тооцно.
- • Орлогын арга: 1.Хөдөлмөрийн хөлс, +2.үндсэн хөрөнгийн хэрэглээ буюу элэгдэл, +3.үйлдвэрлэл, +4.импортын цэвэр татвар, +5.үйл ажиллагааны цэвэр ашиг,+6.холимог орлого зэргийн нийлбэрээр тооцно.

Ихэнх улсууд ДНБ-ийг үйлдвэрлэлийн болон эцсийн ашиглалтын аргаар улирлаар, жилээр тооцдог бөгөөд татварын дарамт, далд эдийн засгийн үйл ажиллагаа зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан орлогын аргаар тооцоход хүндрэл үүсдэг байна. Эдийн засгийн тооцоо судалгаанд эцсийн ашиглалтын аргыг ихэвчлэн ашигладаг бөгөөд энэ нь дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

Тухайлбал: $GDP = Y = C + G + I + (X - M)$

Y - Дотоодын нийт бүтээгдэхүүн,

C – хувийн секторын эцсийн хэрэглээ,

G - Засгийн газрын нийт зардал,

I – хөрөнгө оруулалт буюу капитал тоног төхөөрөмж, бараа материал болон орон сууцанд зарцуулсан нийт хөрөнгийн дүн.

(X – M) - цэвэр экспортын дүн,

X – экспортын хэмжээ,

M – импортын хэмжээ

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2019 оны эхний улиралд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн урьдчилсан гүйцэтгэлээр 3.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.6 хувиар өссөн.



Гэрийн даалгавар

Эдийн засгийн өсөлтийг тухайн онуудад хэдий хэмжээгээр өссөн болохыг тооцоолох даалгаврыг сурах бичгийн 75-80-р хуудаснаас сайтар уншаад хийнэ.

№	Төрөл	2015 он		2016 он	
		Үнэ	Үйлдвэрлэлийн хэмжээ, мян ширхэг (Q)	Үнэ(P)	Үйлдвэрлэлийн хэмжээ, мян ширхэг (Q)
1	Талх	950	700.0	1100	800.0
2	Ургамлын тос	2000	300.0	2300	350.0

$$ДНБ = \sum P_i Q_i = P_1 Q_1 + P_2 Q_2$$

Дараах томъёог ашиглан бодоорой.

$$ДНБ \text{ -ний өсөлт} = \frac{ДНБ_{2016}}{ДНБ_{2015}} \cdot 100\%$$